

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ТӨАГ-2023/28-18-ШТА-ГА

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Л.Жаргалсайхан
Утас: 70273465 Цахим хаяг: jargalsaikhanl@audit.gov.mn

Аудитор Г.Сугармаа
Утас: 70272582 Цахим хаяг: sugarmaag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл..... 3

БҮЛЭГ А. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ БАЙНА.....5

А.2. Аймгийн түвшинд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналаа холбогдох хууль, журам, аргачлалын дагуу хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд оруулж, төлөвлөлт хийгдэж байна.....5

БҮЛЭГ Б. ОРОН НУТАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗАРИМ НЭГ ЗӨРЧИЛ ИЛЭРЧ БАЙНА.....6

Б.1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна..... 6

Б.2. Эрх шилжин хэрэгжиж байгаа зарим төсөл арга хэмжээний батлагдсан төсөв, магадлалын дүгнэлтээр гарсан төсөвт өртгөөс бага байдгаас нэмэлт санхүүжилт шаардлагатай болж байна.....8

Б.3. Эрх шилжин хэрэгжсэн зарим ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгоогүй байна..... 11

Б.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагч, зохиогчийн хяналт тавигдаж байна... 13

Б.5. Барилга байгууламж, авто зам, их засварын 7 ажлыг байнгын ашиглалтад оруулах, хүлээн авах үйл ажиллагааг хууль журмын дагуу хийсэн байна..... 14

БҮЛЭГ В. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 80,7 ХУВЬТАЙ БАЙНА.....15

В.1. Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсөвт хөрөнгө оруулалтын санхүүжилт баталсан байна..... 15

В.2. Аймгийн Засаг даргын захирамжаар сумдын Засаг дарга нарт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна..... 17

ДҮГНЭЛТ:.....23

ЗӨВЛӨМЖ:..... 24

Холбогдох байгуулагын санал:..... 25

Хүснэгтийн товьёг

Хүснэгт 1: ТЕЗ-с аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн байдал.....7

Хүснэгт 2: УТХО-н 2022 оны санхүүжилтийн судалгаа..... 11

Хүснэгт 3: Төсөл, арга хэмжээний худалдан авалтын зохион байгуулалт..... 17

Хүснэгт 4: Он дамжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээний жагсаалт.....20

Хүснэгт 5: Хөрөнгө оруулалтаар бий болсон ч данс бүртгэлд тусгаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт.....22

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БЗОСК	Барилга захиалагч, орон сууцны корпораци
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗДҮАМХ	Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
ЗТХС	Зам тээвэр хөгжлийн сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХААХҮС	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШТС	Шатахуун түгээх станц
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалтыг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол болон Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийлээ.

Аудитын зорилт

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ-т хүргүүлж, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Төв аймагт ТЕЗ-н багцаас эрх шилжиж хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
- Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС, Замын сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Аудитын хамарсан хүрээ

Аудитад 2022 онд аймгийн улсын төсвөөс эрх шилжин хэрэгсэн 21 төсөл арга хэмжээ, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, үүнээс барилга байгууламжийн 53 ажил, их засварын 24 ажил, техник тоног төхөөрөмж, зураг төслийн 2 ажил болон 4 хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын хязгаарлалт

Байхгүй.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”,
- MNS 6817-5:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”,
- MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит”,
- MNS 6817-8:2020 “Төрийн аудит Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын

2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”

- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Эрчим хүчний тухай хууль,
- Авто замын тухай хууль,
- Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”,
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”,
- Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт,
- Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Аймгийн таван жилийн үндсэн чиглэл батлах тухай 02 дугаар тогтоол
- Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 01 дүгээр тогтоол
- Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай 02 дугаар тогтоол

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Г.Сугармаа нар гүйцэтгэв. Аудитын талбарын ажлыг 2023 оны 3 дугаар сарын 05-ны өдрөөс 2023 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр хийж гүйцэтгэн УАГ-т хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн судалгаа, санхүүгийн баримтыг шалгагдагч байгууллагаас хугацаа хоцроож ирүүлсэн.

БҮЛЭГ А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу төлөвлөж байна.

А.2. Аймгийн түвшинд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналаа холбогдох хууль, журам, аргачлалын дагуу хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд оруулж, төлөвлөлт хийгдэж байна.

А.2.1. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар Төв аймагт нийт 342.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2022 онд 52.1 тэрбум төгрөгөөр санхүүжигдэх дүнтэй 35 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ батлагдсан байна. Үүнээс 2022 онд 20.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 21 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг Засгийн газрын тогтоол болон салбарын сайдын тушаалаар Төв аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн байна. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд улсын хэмжээнд гэж батлагдсан арга хэмжээг салбарын сайдын тушаалаар хуваарилан эрх шилжүүлэхэд, Соёлын сайдын 2022 оны 2/1842 дугаар тушаалаар “аймгийн Номын сангийн тоног төхөөрөмж” 20.0 сая төгрөг, Сангийн сайдын 2022 оны 187 дугаар тушаалаар “сумын ЗДТГ-ын барилгын их засвар /Төв.Жаргалант сум/” 180.0 сая төгрөг гэсэн 2 ажил нэмэгдэж нийт 21 барилга, их засвар, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил аудитад хамрагдлаа. Дээрх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжиж дууссаны дараа аймаг, сумд, шат шатны төсвийн захирагчдын өмчлөлд шилжүүлэхэд бүрэн боломжтой байна.

А.2.2. Аймгийн түвшинд Сангийн сайдын 2018 оны 295 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үүсгэн, шаардлагатай мэдээллийг, тооцоолол, бодлогын баримт бичгүүдийн уялдааг оруулж, 1 дүгээр шатны үнэлгээг хийж баталгаажуулан, улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем [/https://pimis.publicinvestment.gov.mn/](https://pimis.publicinvestment.gov.mn/)-ээр холбогдох ТЕЗ нарт илгээсэн байна.

Цахим системд оруулсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын тооцооллыг тухайн шатны ТЕЗ нар төсөл тус бүрээр нь үнэлгээ хийн эрэмбэлж, Сангийн яаманд хянагдсанаар улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдсан байна.

А.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд эрх шилжин хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа ихэнх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүд нь Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна. Гэвч зарим төсөл арга хэмжээнүүдийн хувьд тухайн жилийн төсвийн тухай хуульд тусгагдаж, батлагдсаны дараа зураг төсөл нь батлагджээ. Тухайлбал:

- *Шинээр батлагдсан Зуунмод, Бүрэн сумдын 160 хүүхдийн дотуур байр, Зуунмод сумын Нэгдсэн эмнэлгийн барилгын зураг төсөл 2022 онд*
- *Он дамжин хэрэгжиж байгаа Угтаалцайдам, Лүн, Баянжаргалан сумдын цэцэрлэгийн барилга, Аргалант сумын ЕБС-н их засварын ажлын зураг төсөл 2021 онд тус тус батлагдсан байна.*

Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн 8.3 км авто замын Номт 1-р багийн петровис ШТС-ын уулзвараас урагш бараатын энгэр хүртэл 3 км хатуу хучилттай авто замын газрын зөвшөөрлийг Зуунмод сумын Засаг дарга 2018 онд гаргасан байна. Үлдэх 5.3 км замын зурвас газар нь Сэргэлэн сумын газрын зөвшөөрөлгүй байна.

А.2.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд тусгуулах төсөл арга хэмжээний хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжих

эх үүсвэр, зэрэг холбогдох тооцоог программчлагдсан excel маягтаар гаргаж, боловсруулалт хийсэн байна. Хийсэн тооцооллыг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд татаж оруулснаар ТЕЗ-чид үнэлгээ, эрэмбэлэлт хийж төсвийн төсөлд тусгуулах саналаа Сангийн яаманд хүргүүлсэн байна. Төсөвт нөлөөлөх ачааллыг аймгийн түвшинд тодорхойлдоггүй, холбогдох ТЕЗ нар буюу 2 дугаар шатны үнэлгээнд тооцоолол хийгдсэн байна

А.2.5. Улсын төсөвт батлагдсан төсөл арга хэмжээнүүдээс Төрийн хэмнэлтийн хууль батлагдсантай холбоотойгоор аймгийн МХГ-н барилгын их засварын 321.5 сая төгрөг, Баянцогт сумын ЗДТГ-ын барилгын их засварын 200.0 сая төгрөг, Жаргалант сумын ЗДТГ-ын барилгын их засварын 180.0 сая төгрөг, нийт 701.5 сая төгрөгийн 3 арга хэмжээ төсвийн тодотголоор хасагджээ. Жаргалант сумын ЗДТГ нь гал түймрийн улмаас зориулалтын бус байранд үйл ажиллагаа явуулж байгаа их засвар хийгдэх зайлшгүй шаардлагатай байгаа тул аймаг, орон нутгаас санал хүсэлт явуулж Сангийн сайдын төсвийн багцад их засварын ажлыг тусган хэрэгжүүлж байна.

БҮЛЭГ Б. Орон нутагт улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарим нэг зөрчил илэрч байна.

Б.1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна.

Б.1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд эрх шилжин хэрэгжсэн арга хэмжээнүүдээс 11 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь 2022 онд шинээр батлагджээ. Засгийн газрын 2021 оны 359 дүгээр тогтоолоор 6 ажил, 2022 оны 61 дүгээр тогтоол, ЗГХЭГ-ын дарга, ХХААХҮС, Соёлын сайд, Сангийн сайдын тушаалаар тус тус 1 ажлыг Төв аймгийн Засаг даргад эрх шилжүүлж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.2-д "Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн тохиолдолд шийдвэрийг тухайн жилийн 02 дугаар сарын 01-ний дотор гаргаж, ажлын 3-5 хоногт багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэж заасан. Сангийн сайд, Соёлын сайдын тушаалаар эрх шилжиж ирсэн 2 ажлаас бусад ажлын хувьд журамд заасан хугацаанд эрх шилжин ирж, аймгийн Засаг даргын захирамжаар үнэлгээний хороо байгуулж, захиалагчийг томилон тайлант жилд хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжих боломжтойгоор худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Жаргалант сумын ЗДТГ-ын барилга нь гал түймрийн улмаас их засвар хийгдэх зайлшгүй шаардлагатай болж ЗГХЭГ-н багцад анх батлагдсан боловч төсвийн тодотголоор хасагдаж, улмаар Сангийн сайдын багцад нэмэгдэж тусгагдсанаар эрх шилжүүлэх шийдвэр журамд заасан хугацаанаас хоцорч гарсан байна.

Хүснэгт 1: Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн байдал

№	Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг сая.төг	2022 онд санхүүжих сая.төг	Эрх шилжүүлсэн шийдвэр		Үнэлгээний хороо байгуулсан огноо
							Огноо	Дугаар	
1	XII.1.122	БХБС	Орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээ /Төв, Зуунмод сум/	Барилга байгууламж	6,041.5	900.0	2021.12.01	МУЗГ-н 359-р тогтоол	2022.01.19
2	XIII.1.1.251	БШУС	Дотуур байрны барилга буулгаж, шинээр барих, 160 ор /Төв, Бүрэн сум, 1 дүгээр баг/	Барилга байгууламж	3,351.0	200.0	2021.12.01	МУЗГ-н 359-р тогтоол	2022.01.20
3	XIII.1.1.265	БШУС	Дотуур байрны барилга, 160 ор /Төв, Зуунмод сум, 1 дүгээр баг/	Барилга байгууламж	2,100.0	420.0	2021.12.01	МУЗГ-н 359-р тогтоол	2022.01.20
4	XIII.1.1.337	БШУС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Төв, Жаргалант сум/	Барилга байгууламж	1,500.0	200.0	2021.12.01	МУЗГ-н 359-р тогтоол	2022.01.20
5	IX.2.1.2.6	Сангийн сайд	Сумын ЗДТГ-ын барилгын их засвар /Төв, Жаргалант сум/	Их засвар	180.0	180.0	2022.09.03	СС-ын 2022 оны 187	2022.03.21
6	XV.1.1.53	ЗТХС	Баруун чиглэлд авто замаас Аргалант сумын төв хүртэлх авто зам, 7.1 км /Төв/	Барилга байгууламж	8,434.7	1,300.0	2021.12.01	МУЗГ-н 359-р тогтоол	2022.01.12
7	XIV.3.13	Соёлын сайд	Аймгийн Номын сангийн тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж	20.0	20.0	2022.07.06	СоСайдын А/241	2022.09.05
8	XIX.1.51	ЭМС	Нэгдсэн эмнэлгийн барилга, 50 ор /Төв, Зуунмод сум/	Барилга байгууламж	5,500.0	1,572.9	2022.02.01	МУЗГ-н 61-р тогтоол	2022.02.22
9	XVIII.1.30	ЭХС	Дулааны станцын халаалтын 1, 2, 3, 4, 5, 6, 7 дугаар хэсгийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл /Төв, Зуунмод сум/	Барилга байгууламж	11,632.5	420.0	2021.12.01	МУЗГ-н 359-р тогтоол	2022.01.19
10	XVII.3.27	ХХАА-ХУС	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Төв/	Тоног төхөөрөмж	180.0	180.0	2022.02.01	ХХААХУС-н А/58 А/147	2022.02.23

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Б.1.2. Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/772 дугаар захирамжаар ТЕЗ-ын 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталжээ. Энэ захирамжийн 3 дугаар хавсралтаар хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөл, ТЭЗҮ, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт бэлдэх, барилга угсралт, их засварын ажлын зураг төсвийг магадлал хийлгэж баталгаажуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий захиалагчийг томилсон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжсэн 10 ажлын хувьд аймгийн ГХБХБГ 4 ажил, БЗОСК ОНӨААТҮГ 4 ажил, аймгийн Номын сан, ХХААГ тус тус 1 ажилд захиалагчаар томилогдсон байна.

Засаг даргын захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо нь барилга угсралт, их засвар, тоног төхөөрөмжийн ажлын зураг төсөл, техникийн тодорхойлолтыг үндэслэн Сангийн сайдын баталсан ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичиг, тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт боловсруулж, захиалагч байгууллагаар батлуулж, тендер зарласан байна.

Б.1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд эрх шилжин шинээр хэрэгжсэн 10 ажлын есийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, нэг ажлыг харьцуулалтын аргаар цахимаар зохион байгуулсан байна. Соёлын сайдын багцаас эрх шилжиж ирсэн аймгийн Номын сангийн тоног төхөөрөмж авах 20.0 сая төгрөгийн ажлыг харьцуулалтын аргаар цахимаар зарлаж бусад ажлын гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулж ил тод, нээлттэй өрсөлдөх боломжийг хангасан байна.

Цахимаар нээлттэй тендер шалгаруулалт зарлаж, гүйцэтгэгч шалгараагүй тохиолдолд шууд гэрээ байгуулах хэлэлцээрийг мөн цахим систем ашиглан олон нийтэд нээлттэйгээр гүйцэтгэгчийг шалгаруулжээ. Жишээлбэл: Жаргалант сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын /1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ гүйцэтгэгчийг 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн 2 удаа тендер зарлаж, гүйцэтгэгч шалгараагүй тул ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3¹, 34 дүгээр зүйлийн 34.2²-д заасны дагуу цахимаар 5 удаа хэлэлцээр явуулж 7 дугаар сарын 05-нд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгожээ.

Б.2. Эрх шилжин хэрэгжиж байгаа зарим төсөл арга хэмжээний батлагдсан төсөв, магадлалын дүгнэлтээр гарсан төсөвт өртгөөс бага байдгаас нэмэлт санхүүжилт шаардлагатай болж байна.

Б.2.1. Төв аймагт эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 16 барилга байгууламжийн ажил хэрэгжиж байна.

- БШУС-ын багц шинэ 3, шилжих 5
- ЭМС-ын багц шинэ 1, шилжих 1
- БХБС-ын багц шинэ 1, шилжих 1
- ЗТХС-ын багц шинэ 1, шилжих 2
- ЭХС-ын багц шинэ 1

Эдгээрээс Баянжаргалан сумын цэцэрлэгийн барилга, Баянцогт сумын 15 ортой эмнэлгийн барилга, Зуунмод сумын төвөөс Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам, Эрдэнэсант сумын төвийн 3.2 км авто зам, үерийн ус зайлуулах байгууламж гэсэн барилга байгууламжийн ажил 2022 онд ашиглалтад орж комисс ажиллан хүлээн авсан байна.

Лүн, Угтаалцайдам сумын цэцэрлэгийн барилга, Заамар сумын Хайлааст багийн 320 хүүхдийн сургуулийн барилга, Зуунмод сумын 640 хүүхдийн спортын төрөлжсөн сургуулийн барилгууд 2022 онд дуусах төлөвлөгөөтэй хэдий ч 87,3-90,0 хувийн гүйцэтгэлтэй, он дамжин хэрэгжихээр болсон байна. Энэ нь батлагдсан төсөвт багтаан нэг маягийн иж бүрэн бус зураг төслөөр тендер зарлаж, гүйцэтгэгч шалгаруулж гэрээ хийдэгтэй холбоотой байна. Тухайлбал:

- Угтаалцайдам сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга 1,300.0 сая төгрөгөөр 2021-2022 онд хэрэгжихээр батлагдсан. Тендерийг баглагдсан төсөвт багтаан нэг маягийн зургаар зарлаж, 2021 оны 6 дугаар сарын 14-нд Тэнгэрийн долоон од ХХК 1,245.4 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явц 92 хувьтай байна. Тендер зарлахдаа хуулиар батлагдсан төсөвт өртөгт багтаан барилгын ажлаас хана, хамар ханын ажил, хаалга, цонх, шал, шат довжооны ажил, дотор гадна засал, халаалт, салхивч, дулааны оролтын узель, дотор цэвэр бохир ус, дотор цахилгаан, дотор холбоо дохиолол, гадна дулаан,

¹ энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах

² Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

гадна ус, хангамж, ариутгах татуурга, гүний худаг, гадна цахилгаан, гадна холбоо, гадна тохижилт зэрэг ажлуудыг хасаж зарласан. Барилгын ажлын магадлалын дүгнэлт 2021 оны 9 дүгээр сарын 29-нд гарч, магадлалаар 2,178.2 сая төгрөг болж батлагдсан ба нэмэлтээр 897.4 сая төгрөгийг төсөвт нэмж тусгах шаардлагатай болжээ.

- Лүн сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга 1,500.0 сая төгрөгөөр 2021-2022 онд хэрэгжихээр батлагдсан. Тендерийг батлагдсан төсөвт багтаан нэг маягийн зургаар зарлаж, 2021 оны 6 дугаар сарын 14-нд Төв Цогт-Өлзийт ХХК-тай 1,341.9 сая төгрөгөөр гэрээ байгуулж ажлын явц 87,3 хувьтай байна. Тендер зарлахдаа хуулиар батлагдсан төсөвт өртөгт багтаан барилгын ажлаас гадна инженерийн шугам сүлжээ, шалны ажил, шат довжооны ажил, дотор халаалт, дулаан оролтын узелийн ажил, дотор цахилгаан, дотор холбоо дохиолол, гадна дулаан, гадна бохир ус, гадна цахилгаан, гадна холбоо, гадна тохижилт зэрэг ажлуудыг хасаж зарласан. Барилгын ажлын магадлалын дүгнэлт 2021 оны 9 дүгээр сарын 29-нд гарч, 2,371.8 сая төгрөг болж батлагдсан ба нэмэлтээр 871.9 сая төгрөг шаардлагатай болсон.



Лүн сумын цэцэрлэгийн барилга 2023.04.14-ний байдлаар

- Заамар сумын Хайлааст багийн 320 хүүхдийн сургуулийн барилга 2,865.1 сая төгрөгөөр 2021-2022 онд хэрэгжихээр батлагдсан. Тендерийг батлагдсан төсөвт багтаан нэг маягийн зургаар 2021 оны 6 дугаар сарын 30-нд Алегротовер ХХК гэрээ байгуулж 88.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Барилгын газар шороо, суурь, уурын зуухны барилга, гадна шугам сүлжээний ажлын магадлалын дүгнэлт 2022 оны 01 дүгээр сарын 17, барилгын ажлын магадлалын дүгнэлт 2022 оны 8 дугаар сарын 18-нд тус тус гарсан. Барилгын зураг, төсөв магадлалаар 6,209.9 сая төгрөг болж батлагдсан ба нэмэлтээр 3,350.0 сая төгрөг шаардлагатай болжээ.
- Зуунмод сумын 640 хүүхдийн сургуулийн барилга нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 5,002.6 сая төгрөгөөр 2019-2021 онд хэрэгжихээр батлагдсан. Барилгын ажлыг Эл Си Би ХХК нь 4,885.2 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явц 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 89 хувьтай байна. Энэ барилга нь спортын төрөлжсөн сургууль бөгөөд бассейн, спортын заалтай байхаар төлөвлөгдсөн хэдий ч зураг төсөвт бассейны ажил тодорхой тусгаагдаагүй, мөн спортын заалнууд бетонон шалтай байхаар, гадна холбооны ажил орхигдсон, урлагийн зааланд дуу чимээ тусгаарлагч хавтан төлөвлөгдөөгүй тул бассейны ажил, залны шалыг стандартын дагуу агч модон шал болгох зэрэг нэмэлт ажлуудыг зураг төсөвт өөрчлөлт оруулан магадлалын дүгнэлт гаргуулахаар болсон байна. Урьдчилсан тооцоогоор нэмэлтээр 1,140.0 сая төгрөгийн төсөв барилга хөгжлийн төвд магадлал хийгдэж байна.

Тайлант 2022 онд хэрэгжиж дуусах төлөвлөгөөтэй дээрх ажлуудад нийт 6,459.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт шаардлагатай болсон байна.

Эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд хийгдэх зарим ажлууд дээр мөн л зураг төсөл санхүүжилттэй холбоотой асуудал гарч байна.

Үүнд:

- Жаргалант суманд баригдах 150 ортой цэцэрлэгийн барилга 1,500.0 сая төгрөгөөр батлагдаж, тендер зарлахдаа барилгын гадна шугам сүлжээний ажлыг хасаж зарлажээ.

Нийт 7 удаа тендер зарлаж 2021 оны 8 дугаар сарын 08-нд Халзан хайрхан ХХК 1,499.7 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулсан. 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн магадлалын дүгнэлтээр төсөв 2,560.9 төгрөг болж, нэмэлтээр 1,137.5 сая төгрөг шаардлагатай болжээ.

- Зуунмод сумын 160 хүүхдийн дотуур байрны барилга 2022 оны төсвийн тухай хуульд 2,100.0 сая төгрөгөөр 2022-2023 онд хэрэгжихээр батлагдсан. 2021 онд Барилга хот байгуулалтын яамнаас захиалж хийлгэсэн 160 ортой дотуур байрны барилгын нэг маягийн зураг төсөв магадлалаар 3,400.0 сая төгрөгөөр батлагджээ. Иймд Төв аймагт 2018-2019 онд Эрдэнэ, Батсүмбэр сумдад баригдсан тухайн үедээ 1,600.0 сая төгрөгийн өртөгтэй байсан нэг маягийн зургаар гадна шугам сүлжээ, гадна тохижилтын ажлыг хасаж тендер зарлаж 2022 оны 6 дугаар сарын 03-нд Баян дөрвөлж ХХК 2,095.6 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулж ажлаа эхэлсэн. Одоогоор ажлын явц 20.0 хувьтай байгаа боловч нэмэлт санхүүжилтийн асуудал шийдээдэж байж дуусахаар байна.
- Аймгийн Нээдсэн эмнэлгийн барилгын ажил улсын төсөвт 5,500.0 сая төгрөгөөр батлагдаж, Клаймакс интернэшнл ХХК-тай 5,475.6 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. Анхны зураг төсөл нь газар хөдлөлтийн балл 7 байсныг 8 балл болгож өөрчлөх, дотор зохион байгуулалт, төлөвлөлтийг ашиглагчтай ярилцаж өөрчлөх, гадна тохижилт, зам талбайн ажил нэмэх зэрэг шаардлагаар нэмэлт ажлын даалгавар өгч магадлалаар ороход 6,119.7 төгрөг болж батлагдсан төсвөөс хэтэрч нэмэлт санхүүжилт шаардлагатай болжээ.

Дээрх ажлуудын хувьд нэмэлтээр 3,061.6 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна.

Б.2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан 3 их засварын ажил 2022 онд хэрэгжсэн. Үүнээс:

- Аргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засварын ажил зураг төсөл, батлагдсан хуваарийн дагуу хийгдэж гэрээний хугацаанд буюу 2022 оны 8 дугаар сарын 22-нд хүлээлгэн өгсөн байна.
- Жаргалант сумын ЗДТГ-ын барилга түймэрт өртөж их засвар хийгдэх зайлшгүй шаардлагаар ЗГХЭГ-н даргын багцад 180.0 сая төгрөг батлагдаж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан хэдий ч төсвийн тодотголоор хасагдсан. Улмаар Сангийн сайдын төсвийн багцад тусгагдан 2022 оны 9 дүгээр сард эрх шилжин ирсэн, аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаас 50.0 сая төгрөг, сумын эх үүсвэрээр 26,9 сая төгрөг, нийт 256.9 төгрөгөөр худалдан авах ажиллагааг дахин зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 11 дүгээр сарын 15-нд гэрээ байгуулсан. Гэрээ оройтож байгуулагдсан цаг агаар хүйтэрч, их засварын ажил гүйцэтгэх боломжгүй болсон тул шатсан дээврийг буулгах ажил хийгдэж, их засварын ажлын гэрээг 2023 оны 5 дугаар сарын 01 болгож сунгажээ.
- Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн хичээлийн А байр барилгын засварын ажил 2021 оны 7 дугаар сарын 05-нд эхэлж, 2022 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн ашиглалтад оруулах гэрээтэй боловч гүйцэтгэгч Голден прогресс ХХК-ийн үйл ажиллагаа, хүн хүч, хөрөнгө санхүүгийн чадамжгүй байдлаас шалтгаалан 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн байна. Гэрээний тусгай нөхцөлийн дагуу гэрээний алданги болох 17.0 сая төгрөгийг санхүүжилтээс суутган тооцсон байна.

Б.2.3. Соёлын сайдын 2022 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн А/241 тоот тушаалаар аймгийн Номын санд 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж авах ажил эрх шилжин ирж, үнэлгээний хороо 2022 оны 9 дүгээр сарын 05-нд байгуулагдаж 9 дүгээр сарын 15-с 12 дугаар сарын 02-г хүртэл харьцуулалтын аргаар 7 удаа урилга нийтлэн худалдан авах ажиллагааг явуулан, гүйцэтгэгчийг шалгаруулж 12 дугаар сарын 21-нд гэрээ байгуулжээ. Гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд буюу 2023 оны 01 дүгээр сарын 19-нд техникийн тодорхойлолтод заасан бар код уншигч 3 ширхэг, компьютер, бичгийн шүүгээ, номын ялтас, камер, камерын дуран, карт принтер, карт зэрэг тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.

ХХААХҮС-ын багцаас орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд анх 900.0 сая төгрөг батлагдан эрх шилжсэн боловч төсвийн тодотголоор

180.0 сая төгрөг болж хуваарилагдсаныг 2 багц болгон 100.0 сая төгрөгөөр үржлийн мал нийлүүлэх, 80.0 сая төгрөгөөр зохиомол хээлтүүлэг хийх ажил болгон тендер зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулжээ.

Герефорд, Сэлэнгэ үүлдрийн бухын үрээр зохиомол хээлтүүлэг хийх ажилд Үржлийн шилмэл сүрэг хоршоо шалгарч 2022 оны 6 дугаар сарын 21-нд 79.6 сая төгрөгийн гэрээ байгуулан, хугацаанд нь гүйцэтгэж, хүлээлгэж өгсөн байна. Аймгийн ХХААГ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохиомол хээлтүүлгийн ажилд хяналт тавьж хүлээж авчээ. Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийн тайланд төлөвлөсний дагуу нийт 1050 толгой үнээнд зохиомол хээлтүүлэг хийсэн боловч сум бүрд төлөвлөсөн тоогоор хийгдээгүй тухайлбал, Баян-Өнжүүл суманд 130 толгой үнээнд хийх байсан боловч хийгдээгүй, Баянцогт суманд 130 толгой үнээнд хийх төлөвлөөгөөтэй ч 350 толгой үнээнд хийсэн гэж тусгажээ. Гэтэл гүйцэтгэл хүлээж авсан комиссын актад Аргалант, Баянцогт, Баян-Өнжүүл, Баянцагаан, Дэлгэрхаан, Эрдэнэ, Сэргэлэн сумдад төлөвлөсний дагуу 130-250, нийт 1050 толгой үнээнд зохиомол хээлтүүлэг хийж, хээлийн шалгалт хийсэн гэж баталгаажуулжээ. Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/716 тоот захирамжаар дээрх сумдад зохиомол хээлтүүлэг хийсэн ажлын зардлыг хөдөө аж ахуйн тасгийн хөрөнгөд авлагаар тусган бүртгэж, дараа жилийн 4 дүгээр сард багтаан зохиомол хээлтүүлэг хийлгэсэн малчдаас эргэн төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн байна. Зохиомол хээлтүүлэг хийсэн бодит гүйцэтгэлийг гаргаж дээрх захирамжийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Нутгийн Баянцагаан өсвөр хуц нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр Н Бэлэг ХХК шалгарч 97.2 сая төгрөгийн дүнтэй гэрээг 2022 оны 8 дугаар сарын 19-нд байгуулсан. Аймгийн 20 сум тус бүр 20 толгой нийт 400 толгой өсвөр хуцыг 2022 оны 9 дүгээр сарын 08-с 10 дугаар сарын 07-ны хооронд нийлүүлжээ. Аймгийн ХХААГ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус ажилд хяналт тавьж, гүйцэтгэлийг хүлээж авсан байна. Аймгийн Засаг даргын 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А/522 дугаар захирамжаар өсвөр хуц хуваарилах сумдыг баталж, жилийн дараа өсвөр хуц авах нөхцөлтэй олгохыг сумдын Засаг дарга нарт даалгасан байна. Үүний дагуу аймгийн ХХААГ дээрх 20 сумдын Засаг даргатай гэрээ байгуулан өсвөр хуцыг хүлээлгэн өгчээ.

Б.3. Эрх шилжин хэрэгжсэн зарим ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгоогүй байна.

Б.3.1. Улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар 2022 онд 17,572.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 22 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн. Нийт 8 ТЕЗ-н багцаас ирсэн санхүүжилтээс 18,501.0 сая төгрөг олгожээ. Үүнээс гүйцэтгэгч байгууллагад 14,944.3 сая, зураг төслийн зардалд 280.5 сая, захиалагчийн хяналтын зардалд 220.0 сая, зохиогчийн хяналтын зардалд 52.9 сая, авто замын сан нормчлолын санд 29.2 сая төгрөг олгож, 591.1 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ.

Хүснэгт 2: УТХО-н 2022 оны санхүүжилтийн судалгаа /сая.төг/

ТЕЗ	Төсөл арга хэмжээний тоо	Гүйцэтгэгчид олгосон	Зураг төсөл	ЗХЗ	ЗоХЗ	Авто замын сан	Барьцаа	Нийт олгосон
БХБС	2	985.0	43.1	19.6	9.8	-	12.9	1,070.4
БШУС	10	3,217	144	45	21	1	151	5,939.2
ЗТХС	3	7,709.80	-	110.19	-	27.94	345.85	8,216.90
Сангийн сайд	1	168.8	6.6	3.1	1.5	-	-	180.0

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Соёлын сайд	1	20.0	-	-	-	-	-	20.0
ЭМС	2	2,258.1	86.7	34.3	17.2	-	81.5	2,477.7
ЭХС	1	408.9	-	7.4	3.7	-	0.0	420.0
ХХААХҮС	1	176.8	-	-	-	-	-	176.8
Дүн	21	14,944.3	280.5	220.0	52.9	29.2	591.1	18,501.0

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Санхүүжилтийг олгоходоо Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан журам, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан журмыг баримтлан, захиалагч болон зохиогчийн хяналтаар баталгаажуулсан төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилтийг олгосон байна.

Зарим төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр бус, оны эцэст мөнгө татагдана гэсэн шалтгаанаар санхүүжилтийг бүтэн олгосон тохиолдол гарсан. Тухайлбал:

- *Жаргалант сумын ЗДТГ-н барилгын их засварын ажил оройтож гэрээ хийгдсэн, 12 дугаар сард огцом хүйтэрч гадаа ажиллах боломжгүй болсон тул ажил гүйцэтгэх гэрээг сунгажээ. Оны эцэст шатсан дээвэр, модон хучилт, хучилтын дам нуруу, хаалга, цонх буулгах ажил, барилгын өрөө тасалгаанууд доторх хог хаягдлыг цэвэрлэх болон барилгаас буулгасан хогыг ачиж хаях зэрэг ажил хийгдэж, 22.3 сая төгрөгийн гүйцэтгэл гарчээ. Гэтэл Сангийн сайдын багцаас 2022 оны 12 дугаар сарын 30-нд 180.0 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын данснаас 12 дугаар сарын 26-нд 50.0 сая төгрөг нийт 230.0 сая төгрөг гүйцэтгэгч болон захиалагч, зохиогчийн хяналтын зардал гэж олгожээ.*



Жаргалант сумын ЗДТГ-ын барилга 2023.04.18-ны өдрийн байдлаар

- *Аргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн их засварын ажлын гүйцэтгэгч Тэнгэрийн долоон од ХХК-тай 2022 оны 9 дүгээр сарын 21-нд 19.7 сая төгрөгийн дээврийн усны хаялга хийх нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулж, гүйцэтгэл гарган, 2022 оны 12 дугаар сарын 30-нд олгосон байна. Бодит гүйцэтгэл нь 10.1 сая төгрөг байхад 9.6 сая төгрөг илүү олгожээ.*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8³-д заасныг болон Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө

³ Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

орруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.2.6⁴, 4.3.1⁵-д заасныг зөрчсөн байна.

Б.3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа зарим барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэгчтэй ЗДТГ-ын ХБТХОХ, захиалагч БЗОСК ОНӨААТҮГ, ГХБХБГ нэмэлт гэрээ байгуулж аймгийн Засаг даргаар батлуулсан байна. Үүнд:

- Бүрэн сумын 160 хүүхдийн дотуур байрны барилга угсралтын ажлын гүйцэтгэгч Хөх үзүүр ХХК-тай 2022 оны 9 дүгээр сарын 21-нд 414.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулж, гэрээнд нэмэлт санхүүжилтийг 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаас гэж заасан хэдий ч 2022 оны тендерийн хэмнэлтээс олгосон байна.
- Угтаалцайдам сумын 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч Тэнгэрийн долоон од ХХК-тай 2022 оны 9 дүгээр сарын 21-нд 35.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулжээ. Нэмэлт санхүүжилтийг 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын тендерийн хэмнэлтээс олгохоор тусган, олгосон.
- Лүн сумын 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч Төв цогт өлзийт ХХК-тай 2022 оны 7 дугаар сарын 21-нд 157.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулж, санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын тендерийн хэмнэлтээс олгохоор тусгаж, олгожээ.
- Баянцогт сум 15 ортой эмнэлгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч Арбулаг ХХК-тай 2022 оны 9 дүгээр сарын 21-нд 84.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулж, санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын тендерийн хэмнэлтээс олгохоор тусгаж, олгосон байна.
- Аргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн их засварын ажлын гүйцэтгэгч Тэнгэрийн долоон од ХХК-тай 2022 оны 9 дүгээр сарын 21-нд 19.7 сая төгрөгийн дээврийн усны хаялга хийх нэмэлт санхүүжилтийн гэрээ, 2022 оны 12 дугаар сарын 09-нд гэрээний хугацаа 2022 оны 7 дугаар сарын 22-нд дуусах байсныг 2023 оны 6 дугаар сарын 15 болгон сунгалт хийсэн гэрээг тус тус байгуулж, нэмэлт санхүүжилтийг олгосон.

Тухайн жилийн тендерийн хэмнэлтээс нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулан, олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3⁶-д “гэж заасныг зөрчсөн байна.

Гэрээний гүйцэтгэх хугацааг нэмэлт гэрээ байгуулан өөрчлөлт оруулан, сунгасан 2 гэрээ хийгдсэн байна.

- Заамар сумын Хайлааст багийн 320 хүүхдийн сургуулийн барилгын ажлын гүйцэтгэгч Алегротовер ХХК-тай 2022 оны 9 дүгээр сарын 21-нд гэрээний хугацаа 2022 оны 8 дугаар сарын 10-нд дуусах байсныг 2022 оны 12 дугаар сарын 25 хүртэл, 2023 оны 02 дугаар сарын 14-нд гэрээний хугацааг 2023 оны 12 дугаар сарын 25 хүртэл сунгаж нэмэлт гэрээ байгуулжээ.
- Жаргалант сумын ЗДТГ-ын барилгын их засварын ажлын гүйцэтгэгч Тусгал төв ХХК-тай 2022 оны 12 дугаар сарын 27-нд ажил гүйцэтгэж дуусах хугацааг 2022 оны 12 дугаар сарын 28 байсныг 2023 оны 5 дугаар сарын 10 болгож нэмэлт гэрээ байгуулсан.

Б.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагч, зохиогчийн хяналт тавигдаж байна.

Б.4.1. Улсын төсвийн хөрөнгөөр эрх шилжин хэрэгжсэн 21 ажлын 14 ажилд БЗОСК ОНӨААТҮГ, 5 ажилд ГХБХБГ, тоног төхөөрөмж нийлүүлэх 2 ажилд аймгийн ХХААГ, Номын сан захиалагчаар томилогдон ажилласан байна.

⁴ 2.3.2.6.төслийн санхүүжилт хүссэн гүйцэтгэлд ирүүлж буй холбогдох баримт бичиг, мэдээллүүдийн иж бүрдэл, үнэн зөв эсэхэд бүрэн хариуцлага хүлээнэ

⁵ Захиалагч их засварын ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон их засварын ажлын календарьчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдлаар гаргаж, энэ журмын хавсралт №8 болон №9-д заасан маягтын дагуу гаргана

⁶ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх

Захиалагч нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3-д заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.

Захиалагчаар томилогдсон хяналтын инженерүүд нь үе шатны гүйцэтгэл бүрд хяналт хэрэгжүүлж, баталгаажуулсан байна. Мөн Дэд бүтцийн сайдын 2000 оны 09 тоот тушаалаар батлагдсан “Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл” буюу улаан дэвтэрт хяналтаар ажиллахад илэрсэн дутагдлыг арилгах талаар зөвлөмж бичиж байгаа боловч бүрэн гүйцэт биш, өгсөн зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж ажилласныг тэмдэглэхгүй байна.

Зуунмод сумын төвөөс Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам, Баруун чиглэлд явсан авто замаас Аргалант сумын төв хүртэлх авто зам гэсэн 2 ажилд захиалагч БЗОСК ОНӨААТҮГ нь Мөнхөд ашдын зам ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна. Зөвлөх үйлчилгээ буюу хяналт хэрэгжүүлж буй ААН нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж сар бүр тайлан гаргаж, захиалагчтай уулзалт хийн, тэмдэглэл хөтлөн ажилласан байна.

Барилга угсралт, их засварын 16 ажилд зураг төсөл зохиогчтой гэрээ байгуулан зохиогчийн хяналтын хэрэгжүүлж, гэрээний дагуу 52.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжсэн болон хэрэгжиж буй 21 төсөл арга хэмжээнд мэргэжлийн байгууллагын хяналт хийгээгүй байна.

Б.4.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сум орон нутагт хэрэгжиж буй ажилд тухайн сумын удирдлага, ЗДТГ, ашиглагч байгууллагууд тодорхой хэмжээний хяналт хэрэгжүүлдэг боловч, цаасаар зөвлөмж, шаардлага, тэмдэглэл үйлддэггүйгээс хяналт хэрэгжиж байна гэж үзэхэд учир дутагдалтай байна.

Б.5. Барилга байгууламж, авто зам, их засварын 7 ажлыг байнгын ашиглалтад оруулах, хүлээн авах үйл ажиллагааг хууль журмын дагуу хийсэн байна.

Б.5.1. Улсын төсвөөс эрх шилжин хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнээс дараах ажлууд 2022 онд бүрэн хэрэгжиж, ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.

- БХБС-ын багцаас эрх шилжин хэрэгжсэн ажлаас Зуунмод сумын үерийн ус зайлуулах байгууламж,
- БШУС-ын багцаас эрх шилжсэн Баянжаргалан сумын цэцэрлэгийн барилга, Аргалант сумын ЕБС-ийн барилгын их засварын ажил, Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн хичээлийн А байрны их засварын ажил,
- ЭМС-ын багцаас эрх шилжсэн Баянцогт сумын эмнэлгийн барилга,
- ЗТХС-ын багцаас эрх шилжсэн Зуунмод сумын төвөөс Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто зам, Эрдэнэсант сумын төвийн 3.2 км авто зам

Дээрх төсөл арга хэмжээнүүдийг ашиглалтад хүлээж авахад Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан журамд заасны дагуу комисс ажиллаж өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг дүгнэж, байнгын ашиглалтад оруулах дүгнэлт гаргаж албажуулсан байна.

Б.5.2. Хэрэгжиж дууссан эдгээр төсөл арга хэмжээний гэрээг дүгнэн, гэрээний үүргийн хэрэгжилтийг тооцон Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор

батлагдсан журмын хавсралт 12 дугаар маягтаар баримтжуулж баталгаажуулсан байна.

Б.5.3. Байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн дээрх хөрөнгө оруулалтын ажлууд нь зориулалтын дагуу ашиглагдаж байгаа бөгөөд Зуунмод сумын үерийн ус зайлуулах байгууламж, Зуунмод сумын төвөөс Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн авто замын ажлуудыг данс бүртгэлд тусгаагүй байна.

БҮЛЭГ В. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 80,7 ХУВЬТАЙ БАЙНА.

В.1. Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсөвт хөрөнгө оруулалтын санхүүжилт баталсан байна.

В.1.1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1–д заасны дагуу аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдийг баталжээ. Тухайлбал:

- ✓ *Аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор “Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,*
- ✓ *Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”,*
- ✓ *Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/01 дүгээр захирамжаар “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”,*
- ✓ *Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө”-г тус тус баталсан байна.*

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн VII хуралдааны 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар /шилжих үлдэгдлийн эх үүсвэрээр/ 6,324.6 сая төгрөгөөр 27, тогтоолын 3 дугаар хавсралтад замын сангийн хөрөнгөөр 1,026.5 сая төгрөгөөр 8, тогтоолын 4 дүгээр хавсралтад аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 6,212.5 сая төгрөгөөр 39, тогтоолын 5 дугаар хавсралтад 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварт 1,206.9 сая төгрөгөөр 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн X дугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор 2022 оны төсвийн тодотголыг баталж, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг дараах байдлаар өөрчилжээ. Үүнд:

- *Тогтоолын 1 дүгээр хавсралтаар аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар /шилжих үлдэгдлийн эх үүсвэрээр/ 6,324.7 сая төгрөгөөр 16 төсөл арга хэмжээг,*
- *Тогтоолын 2 дугаар хавсралтаар аймгийн ОНХС-н хөрөнгө оруулалтаар 5,996.7 сая төгрөгөөр 24 ажил, төсөл, арга хэмжээг,*
- *Тогтоолын 3 дугаар хавсралтаар ОНХС-н шилжих үлдэгдлээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд 540.7 сая төгрөгийн 8 ажил, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус батласан.*

Аймгийн ИТХ-ын 2021 оны 03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Замын сан” болон 5 дугаар хавсралт “Аймгийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын жагсаалт”-д өөрчлөлт оруулаагүй байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх барилга, байгууламж, төсөл арга хэмжээний жагсаалтад “аймаг хөгжүүлэх сангийн эх үүсвэрт хөрөнгө төвлөрүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах болон бусад төсөл, хөтөлбөр

хэрэгжүүлэх зардал, зээлийн эрсдэлийн батлан даалтын санд хөрөнгө төвлөрүүлэх” зэрэг хөрөнгө оруулалтын бус урсгал зардлуудыг жил бүр тусгаж байна.

Аудитад хамрагдсан төсөл, арга хэмжээнүүдээс Угтаалцайдам сумын соёлын төвийн барилгын дээврийн их засварт 90.0 сая төгрөг, БОАЖГ болон 6 сумын онцгой комисс, шуурхай штабын автомашин шинэчлэх зардалд нийт 430.0 сая төгрөг, гэр төсөл хэрэгжүүлэхэд 100.0 сая төгрөг, адууны хэмжилтийн лазер төхөөрөмж худалдан авах, суурилуулах зардалд 15.0 сая төгрөг, аймгийн стадионы барилгын их засварт 500.0 сая төгрөг, Эрдэнэ сумын соёлын төвийн барилгын их засварт 250.0 сая төгрөг, 4 суманд хүүхдийн хөдөлмөр зуслан байгуулах ажилд 111.7 сая төгрөг зэрэг төсөл арга хэмжээнүүд нь аймгийн ЗДҮАМХ, үндсэн чиглэл болон 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д “Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт ... аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, орон нутгийн төсөв хамаарна”, 6.10.4-д “Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж заасантай нийцэхгүй байна. Бусад төсөл, арга хэмжээ нь аймгийн ЗДҮАМХ, үндсэн чиглэл болон 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд ерөнхий нэршлээрээ тусгагдсан байна.

В.1.2. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” гэж тус тус заасан.

Аймгийн 2022 оны төсөв болон тодотгосон төсөвт батлагдсан ажлуудаас Соёл амралтын хүрээлэн болон 5-р багийн айл өрхийн суурьшлын хөрсний ус шүүрүүлэх, зайлуулах шугам татах ажил /Зуунмод/-ын төсөв 2021 онд, Гэр хороолол, нийтийн орон сууц, үйлчилгээний газруудыг төвлөрсөн халаалтад холбох ажил /5 сум/-ын төсвийг 2018 онд хийсэн байна. Харин Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /7 сум/-д нэг суманд 100.0 сая төгрөгөөр 2 айлын орон сууц барихаар нэг маягийн зураг төсвийг 2022 онд хийсэн. Зуунмод хотын 1, 2-р хэсгийн халаалтын зуухыг шинэчлэх ажлын зургийг хийлгэхээр 2022 оны 4 дүгээр сарын 15-нд гэрээ байгуулж, 8 сард хүлээн авсан. Гэр хорооллын цахилгаан хангамжийг шинээр хийх ажлын техникийн нөхцөлийг 2022 оны 3 дугаар сарын 10-нд олгосон, Гэр хорооллын цахилгаан хангамжийг шинээр хийх ажил /Зуунмод, Номт баг, жишиг 2 хороолол/-ын төсөв 2022 онд хийгдсэн байна.

Аймгийн 2022 оны төсөв батлах тухай тогтоолд батлагдсан “Цахилгаан хангамжийг сайжруулах ажил /Өндөрширээт”-ын худалдан авах ажиллагааг 2022 оны 4 дүгээр сарын 02-нд НТШ-ын журмаар зохион байгуулж, 6 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулсан байхад тодотгосон төсөв баталсан тогтоолд тусгахгүй орхигдуулсан байна.

В.2. Аймгийн Засаг даргын захирамжаар сумдын Засаг дарга нарт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна.

В.2.1. Аймгийн Засаг даргын 2021 оны А/772 дугаар “Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах, эрх шилжүүлэх тухай” захирамжаар 2,530.0 сая төгрөгийн 29 төсөл арга хэмжээг 2022 оны А/38 дугаар “Эрх шилжүүлэх тухай” захирамжаар 1,265.0 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээ нийт 3,795.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 44 төсөл арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 45 дугаар зүйлийн 45.6-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга нь шаардлагатай гэж үзвэл сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт энэ хуулийн 45.2.2-т заасан эрхээ шилжүүлж болно” гэснийг үндэслэн 26 суманд эрх шилжүүлэн хэрэгжүүлэхээр баталжээ. Мөн батлагдсан санхүүжилтийг сумдад хуваарилж, гэрээ шууд байгуулах аргаар Хүүхдийн хөдөлмөр зуслан байгуулах төсөл арга хэмжээг 4 суманд 111.7 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 3: Төсөл, арга хэмжээний худалдан авалтын зохион байгуулалт

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Худалдан авах ажиллагааны арга				Нийт
		Нээлттэй тендер шалгаруулалт	Харьцуулалтын арга	Шууд худалдан авалт	Бага үнийн арга	
1	Шилжих үлдэгдэл	13	16	2	1	32
2	ОНХС	13	23	9	-	45
3	Замын сан	2	-	3	1	6
	Нийт	28	38	14	2	83

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Аймгийн шилжих үлдэгдлээр санхүүжих 2, ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих 1 нийт 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч оролцогчгүй шалтгаанаар хойшилсоор хэрэгжих боломжгүй болсон байна.

Зарим төсөл арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг баталж, сумдад эрх шилжүүлэн худалдан авах арга хэмжээг зохион байгуулсан байна.

- Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд 7 суманд 100.0 сая төгрөг, нийт 700.0 сая төгрөг,
- Аймаг, сумын Онцгой комисс, шуурхай штабын автомашин шинэчлэх зардалд 6 суманд 60.0 сая төгрөг, БОАЖГ-т 70.0 сая төгрөг нийт 430.0 сая төгрөг
- Гэр хороолол, нийтийн орон сууц, үйлчилгээний газруудыг төвлөрсөн халаалтад холбох ажил 5 суманд 80.0 сая төгрөг нийт 400.0 сая төгрөг
- Сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах ажлын оролцоо 11 суманд 60.0 сая төгрөг нийт 660.0 сая төгрөг.

Төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагаатай холбоотой дараах нийтлэг зөрчил илэрлээ. Үүнд:

- Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх /Аргалант/ ажилд Үнэлгээний хорооны гишүүдийг томилсон сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/34 дүгээр захирамжид заасан 5 гишүүнд нэр нь ороогүй 1 хүнийг үнэлгээний хороонд ажиллуулсан,

- Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийн огноо ижил, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдээдэлд 3 төсөл арга хэмжээний 3 гишүүн, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдээдэлд 3 төсөл арга хэмжээний 7 гишүүн тус тус гарын үсэг зурж баталгаажуулаагүй,
- Төндөрт шалгарсан аж ахуй нэгж нь Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 30 дугаар тушаал "Барилгын төсөв зохиох дүрэм"-г баримтлаагүй, ТШЗ-д төсөвт өртөгийн 0.5 хувиар тооцож төндөрийн баталгааг ирүүлэхээр заасан байхад ирүүлээгүй, өөр аймгийн төрийн байгууллагад хаягласан лавлагаа, тодорхойлолттой ААН-г шалгаруулсан,
- Төндөрт шалгарсан ААН-д 6 хоногийн дараа гэрээ байгуулах тухай мэдээдэл хүргүүлсэн байхад уг хугацааг хэтрүүлж, гэрээ байгуулсан
- Ажил гүйцэтгэх гэрээнүүдэд хийж гүйцэтгэх ажлын нэр төрлийг хянахгүйгээр буруу тусгасан гэх мэт

Аймгийн ОНХС-аас Зуунмод сумын соёл амралтын хүрээлэнгийн барилгын их засвар хийх ажилд 500.0 сая төгрөг баталж нээлттэй тендер шалгаруулалтын журмаар худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Төсөвт тусгасан 500.0 сая төгрөгийг дараах ажлуудыг санхүүжүүлэхээр баталжээ. Үүнд:

- А блокийн засварын ажилд 102.6 сая төгрөг,
- В, F блокийн засварын ажилд 67.2 сая төгрөг,
- С, D блокийн засварын ажилд 127.7 сая төгрөг,
- Е блокийн засварын ажилд 78.5 сая төгрөг,
- Гадна цэвэр, бохир усны шугамын засварын ажилд 46.7 сая төгрөг.

Тус ажлын худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5⁷-т заасны дагуу гэрээ шууд байгуулсан байна. Зуунмод сумын соёл амралтын хүрээлэнгийн барилгын их засвар хийх ажилд давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас шууд гэрээ байгуулсан гэж захиалагч байгууллагаас тайлбарлаж байгаа ч тухайн нөхцөл байдлыг тогтоосон мэргэжлийн байгууллагын үнэлгээ, дүгнэлт зэрэг холбогдох баримтыг аудитын явцад ирүүлээгүй болно.

Түүнчлэн аймгийн Засаг даргын 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А/306 дугаар захирамжаар Зуунмод сумын Соёл амралтын хүрээлэнгийн орчимд үүссэн байгалийн давагдашгүй хүчин зүйл болох хөрсний усны шүүрэлтээс хөшөөний сууринд суулт үүсэн нурж, хүүхэд аюул осолд орох нөхцөл байдал үүссэн тул Морьтой өндөрлөгийг сэргээн босгох зардалд 45.8 сая төгрөгийн зардлыг төсвийн шилжих үлдэгдлийн гамшгийн эрсдэлийг бууруулах болон бусад төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхээр баталсан байна. Тус захирамжийн дагуу "Нью прожект констракшн" ХХК-тай 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр гэрээ шууд байгуулан, гүйцэтгэлийг 12 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон байна. Мөн аймгийн Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А/396 дугаар "Зардал гаргах тухай" захирамжаар үндэсний их баяр наадмыг угтаж хийгдэх Зуунмод сумын соёл амралтын хүрээлэн, наадмын талбайн засварын ажилд зориулж 237.8 сая төгрөгийг газрын дуудлага худалдааны орлогоос санхүүжүүлэхээр баталсан байна. Тус санхүүжилтээр дараах ажлуудыг мөн шууд гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлсэн байна. Үүнд:

- В блокийн саравч 72.6 сая төгрөг,
- F блокийн саравч 72.6 сая төгрөг,
- Шагайн байр 30.3 сая төгрөг,
- **Морьтой хөшөөний түр хаалт 24.9 сая төгрөг,**
- Е блокийн суудлын доод төмөр 11.7 сая төгрөг,

⁷ 34.1.5 гамшгийн онц нөхцөл байдал зарласан, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол;

- С блокийн суудлын доод төмөр 7.5 сая төгрөг,
- А, В, F блокийн суудлын доод төмөр 7.5 сая төгрөг,
- D блокийн суудлын доод төмөр 7.3 сая төгрөг,
- Явган зам, тойрог зам засвар 1.2 сая төгрөг

Зуунмод сумын соёл амралтын хүрээлэнгийн их засварт аймгийн ОНХС, газрын дуудлага худалдааны орлого, гамшгийн эрсдэлийг бууруулах болон бусад төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас нийт 698.8 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын А/306 дугаар захирамжаар 45.8 сая төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэсэн Морьтой өндөрлөгийг сэргээн босгох ажилд мөн А/396 дугаар захирамжаар түр хаалт хийхэд 24.9 сая төгрөгийг зарцуулж, шууд гэрээ байгуулсан нь үр ашиггүй худалдан авалт болсон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁸-т заасантай нийцэхгүй байх тул мэргэжлийн шинжээч томилуулж, шалгуулах саналтайгаар ҮАГ-т хүргүүлээ.

Худалдан авах ажиллагаатай холбоотой дээрх зөрчлүүдийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага бичлээ.

Сумын төвийн цэвэр усан хангамжийн даралтад цамхгийн барилга угсралтын ажил /Дэлгэрхаан сум/-н ажилд 185.6 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна. Төсөв баталсны дараа 2022 онд магадлалаар хянагдсан төсөв нь 183.3 сая төгрөг байхад баталсан санхүүжилтийн дүнгээр тендер зарлан 185.3 сая төгрөгийн гэрээг байгуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁹-т заасныг зөрчин, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй төсөл арга хэмжээг баталснаас шалтгаалж байна.

В.2.2. Худалдан авах төлөвлөгөөнд тусгасны дагуу 2022 оны төсвийн жилд 83 төсөл арга хэмжээнээс 65 нь 100 хувь хэрэгжиж дууссан байна. Эдгээр 65 төсөл арга хэмжээнээс 48 төсөл арга хэмжээний гэрээг дүгнэж, байнгын ашиглалтад авсан ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, улсын комиссын акт зэргээр баталгаажуулсан байна.

Цахилгаан хангамжийг сайжруулах ажил /Баянцогт, Гуна баг/-д гэрээ байгуулснаас хойш холбогдох зөвшөөрөл олгогдож, зураг төсөв бэлэн болсон тул гэрээнд заасан хугацаанд ажил гүйцэтгэх боломжгүй болж, гүйцэтгэл хоцорсон байна. Манзуширын амны төлбөр хураах цэг, авто зогсоол байгуулах ажилд 350.0 сая төгрөгийн төсөв батлагдсан ба уг төсөвт багтаан түлхүүр гардуулах нөхцөлөөр тендер зарлаж, тендерт оролцогч нь ерөнхий төлөвлөгөөний дагуу орчны тохижилт хийгдсэн эскиз зураг, ажлын урьдчилсан төсвийг томсгосон нормоор тооцож ирүүлэхээр заасны дагуу гүйцэтгэгч компани 349.1 сая төгрөгийн үнийн санал ирүүлж, гэрээ байгуулсан боловч зураг төсөв нь магадлалаар хянагдаад 943.9 сая төгрөг болж төсөв нэмэгдэхээр болсноос шалтгаалж хугацаандаа бүрэн хэрэгжих боломжгүй болжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасныг зөрчиж, санхүүжилт баталснаас шалтгаалжээ.

Зуунмод сумын соёл амралтын хүрээлэнгийн барилгын их засвар хийх ажилд 500.0 сая төгрөг баталж, 5 багцад хуваан 415.6 сая төгрөгийн гэрээг 5 ААН-тэй байгуулан гүйцэтгүүлсэн байна.

⁸ 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

⁹ 29.4. Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

Тус ажлыг аудитын явцад газар дээр нь үзэж, шалгахад хөрсний усны шүүрэлт ихтэй, газар хөлдөж, гэссэнээс шалтгаалж засварын ажлууд үр дүнгүй болжээ.



А блокийн засварын ажлын дараах байдал 2023.04.19
/хөрсний ус нэвчсэн, хаалга гажиж, явган хүний зам хагарсан байдал/

Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2022 онд эхэлж, дуусгахаар баталсан дараах төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулж, оролцогчгүй шалтгаанаар 1-5 удаа зарлаж оны сүүл буюу 10-12 дугаар саруудад гэрээг байгуулснаар он дамжин хэрэгжихээр болжээ. Энэ нь Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4¹⁰-т заасныг зөрчсөн байна.

Хүснэгт 4: Он дамжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Худалдан авах ажиллагаа зарлагдсан байдал	Гүйцэтгэгч компанийн нэр	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний дүн	Ажил гүйцэтгэх хугацаа
Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт /шилжих үлдэгдэл/						
1	Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /Аргалант/	5	ӨММ дэвжих цахим ХХК	2022.10.21	100,000,000	2022.10.24-2023.07.01
2	Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /Бүрэн/	5	Хаппи лайнд констракшн ХХК	2022.12.15	100,000,000	2022.12.13-2023.05.01
3	Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /Эрдэнэ/	2	Ихрийн бууц ХХК	2022.10.03	308,151,355	2022.10.03-2023.07.01
4	Сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах ажлын оролцоо /Алтанбулаг/	2	Аймгийн ОНХС Голден эко арт ХХК	2022.04.29	59,984,750	2022.05.15-2022.07.01
5	Сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай	5	Азиякомплект монтаж ХХК	2022.11.25	59,662,835	2023.04.01-2023.04.30

¹⁰ 13.1.4-т "Төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

6	байгуулах ажлын оролцоо /Батсүмбэр/	4	Төв гэрэл ХХК	2022.10.14	59,950,000	2022.10.14-
	Сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах ажлын оролцоо /Зуунмод/					2022.11.14
7	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Алтанбулаг/	1	Халзанхайрхан ХХК	2022.08.22	822,892,709	2022.09.01-2022.12.01
	ЭМТ-ийн өргөтгөлийн ажил /Заамар сум/	2	Заамар констракшн ХХК	2022.11.08	656,013,576	2022.11.14-2023.06.01
8	Төвийн авто зам дагуу явган хүний зам барилгын ажил /Зуунмод/	5	Автозамын сан	2022.11.04	350,898,860	2022.11.04-2022.12.31
			Чингисийн отог ХХК			

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

В.2.3. Автозамын зураг, төсөл боловсруулах ажил /Сэргэлэн, Лүн, Зуунмод/ ажлыг 100 хувь гүйцэтгэн хүлээлгэн өгсөн байхад санхүүжилтийг дутуу олгосон байна.

Санхүүжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- *Аймгийн Засаг даргын 2022 оны А/396 дугаар захирамжаар “Үндэсний их баяр наадмыг угтаж хийгдэх Зуунмод соёл амралтын хүрээлэн, наадмын талбайн засварын ажилд зориулж 237.8 сая төгрөгийн зардлыг баталж, уг зардлыг газрын дуудлага худалдааны орлогоос санхүүжүүлэхээр баталсан байна. Тус засварын ажилд тусгагдсан В, F блокийн саравч хийх ажилд 145.2 сая төгрөг батлагдсанаас 120.7 сая төгрөгийг аймгийн ОНХС-аас зарцуулсныг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данснаас шилжүүлж, залруулсан байна.*
- *Сумдад спорт, чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах /Борнуур/ ажлын санхүүжилтийг олгохдоо магадалшгүй ажлын акт, хурлын тэмдэглэлээр баталгаажуулаагүй байхад 0.4 сая төгрөгийг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт бичлээ.*

В.2.4. Аймгийн Засаг даргын 2021 оны А/772 дугаар “Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах, эрх шилжүүлэх тухай” захирамжаар захиалагчаар томилогдсон БЗОСК ОНӨААТҮГ, ГХБХБГ-аас хэрэгжүүлсэн хяналт үр дүнтэй байна. Харин аймгийн Засаг даргын захирамжийн дагуу сумдад эрх шилжүүлэн хэрэгжсэн төсөл арга хэмжээнд тухайн сумын удирдлага, ЗДТГ, ашиглагч байгууллагууд тодорхой хэмжээний хяналт хэрэгжүүлдэг гэх боловч холбогдох баримтаар баталгаажуулаагүй, захиалагчийн хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй байна.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн захиалагчийн хяналтын зардалд 136.3 сая төгрөг, инженер хайгуул, зураг төсөл болон зураг төсөл зохиогчийн хяналтын зардалд 106.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, чанарын баталгааны барьцаанд 435.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

В.2.5. Захиалагч байгууллагаас гүйцэтгэлийн баримт бичгийг ашиглагч байгууллагад бүрэн шилжүүлдэггүйгээс хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон өмч, хөрөнгүүдийг бүртгэлд авах ажиллагаа хангалтгүй байна.

Хүснэгт 5: Хөрөнгө оруулалтаар бий болсон ч данс бүртгэлд тусгаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Захиалагч байгууллага	Гүйцэтгэгч компани	/төгрөгөөр/ Гэрээний дүн
1	Баянхошуу чиглэлийн автозамын шинэчлэлтийн ажил /Зуунмод/	БЗОСК ОНӨААТҮГ	Шилдэг зам ХХК	485,063,285
2	Цэцэрлэгийн барилгын гадна фасад, дулаалга / Борнуур /	БЗОСК ОНӨААТҮГ, Борнуур сумын ЗДТГ	Есөн хэлхээ ХХК	95,958,512
3	Адууны хэмжилтийн лазер төхөөрөмж худалдан авах, суурилуулах зардал	Аймгийн ЗДТГ	ХҮРД ЭЙ БИ БИ ХХК	15,000,000
4	Манзушир чиглэлийн автозамын эхлэлийн уулзварын зам засварын ажил	БЗОСК ОНӨААТҮГ	Ялгуусан ХХК	389,237,383
5	Гэр хорооллын худаг, усан хангамж шинээр хийх ажил /Зуунмод, Номт баг, жишиг 2 хороолол /	Зуунмод сумын ЗДТГ	Сэрүүн хараат ХХК	19,935,000
6	Цахилгаан хангамжийг сайжруулах ажил /Баянцогт, Гуна баг /	БЗОСК ОНӨААТҮГ, Баянцогт сумын ЗДТГ	Хустайншил	70,951,223
7	Зуунмод сумын хогны тусгай зориулалтын машин	Зуунмод сумын ЗДТГ	Технологи бридж ХХК	19,878,360
8	Эко бин хогийн сав /Зуунмод/	Зуунмод сумын ЗДТГ	Технологи бридж ХХК	19,912,531
9	Хогны касс машин /Зуунмод/	Зуунмод сумын ЗДТГ	Технологи бридж ХХК	19,912,531
10	Автозамын зураг, төсөл боловсруулах ажил /Сэргэлэн, Лүн, Зуунмод/	БЗОСК ОНӨААТҮГ	Эм Ай Эл ХХК	99,297,000
11	Хүмүүн цэцэрлэгийн дотор халаалтын их засвар /Зуунмод сум/	БЗОСК ОНӨААТҮГ	Мөнхчандмань илч ХХК	214,859,439
12	Дунд сургуулийн барилгын их засвар /Баянцогт сум/	БЗОСК ОНӨААТҮГ, Баянцогт сумын ЗДТГ	Густокек ХХК	47,541,113

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Аймгийн түвшинд Сангийн сайдын 2018 оны 295 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний мэдээлэл, тооцоолол, бодлогын баримт бичгүүдийн уялдааг улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд оруулж, 1 дүгээр шатны үнэлгээг хийж байна.
- Улсын төсөвт батлагдсан дүнд тааруулж иж бүрэн бус зураг төслөөр тендер зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулж, ажил эхлүүлж байгаагаас нэмэлт төсвийн асуудал шийдэгдэж байж ашиглалтад хүлээлгэн өгөхөөр болсон хэд хэдэн барилга, байгууламж байна.
- Зарим ажлуудад тендер зарлахад ажлын тоо хэмжээ дутуу тусгагдсан гэдэг үндэслэлээр тухайн жилийн тендерийн хэмнэлтээс нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулан олгосон, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих зарим төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн байхад гэрээ байгуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна.
- Улсын төсвийн хөрөнгөөр эрх шилжин хэрэгжсэн зарим ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгоогүй байна.
- Сумдад эрх шилжүүлэн хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа ТБОНӨХБАҮХАТ хуульд нийцэхгүй байна.
- Аймгийн Засаг даргын 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А/306 дугаар захирамжаар Зуунмод сумын соёл амралтын хүрээлэнгийн Морьтой өндөрлөгийг сэргээн босгох ажилд 45.8 сая төгрөг баталсан хэдий ч хийгдээгүйн улмаас баяр наадам болохтой холбогдуулан дахин 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А/396 дугаар захирамжийн дагуу 24.9 сая төгрөгөөр түр хаалт хийлгэн төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.
- Сумдад эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээнүүдэд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:


Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлд үндэслэн Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, ХБТХОХ-ийн дарга Д.Саран-Эрдэнэ нарт зөвлөх нь:


- Магадлалын дүгнэлтээр батлагдсан зураг, төсөвтэй ажилд санхүүжилт баталж, худалдан авах ажиллагаа зохион байгуулах
- Төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн төсөл, арга хэмжээг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулахгүй байх, тендерийн хэмнэлтээс нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулан олгож буй зөрчлийг давтан гаргахгүй ажиллах,
- Барилга байгууламж, их засварын ажлын төсөл, арга хэмжээг сумдад эрх шилжүүлэхгүй байх, захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар хэрэгжүүлэх

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Гантулгад зөвлөх нь:


- Засгийн газрын “Шинэ хөдөө хөтөлбөр”-ийн хүрээнд 8 суманд хийсэн зохиомол хээлтүүлгийн ажлыг бодит гүйцэтгэлээр тооцон хяналт тавьж ажиллах


Тайлан хянасан:


Дарга, Тэргүүлэх аудитор:  Ц.Хишигжаргал

Аудитын менежер:  О.Амаржаргал

Тайлан бичсэн:

Ахлах аудитор:  Л.Жаргалсайхан

Аудитор:  Г.Сугармаа



Холбогдох байгууллагын санал:



**ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

41111 Төв аймаг, Зуунмод сум, Ногоо гэрээний байр
Утас: 70273623, Факс: 70273237

2023.04.20 № 02/728

Тайлбар: _____

**ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.ХИШИГЖАРГАЛ ТАНАА**

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Тус тайлангийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж хамтран ажиллах болно.

ДАРГА  М.ОТГОНБАТ



SS

4100300710



**ТӨВ АЙМАГ
БАРИЛГА ЗАХИАЛАГЧ ОРОН
СУУЦНЫ КОРПОРАЦИ ОНӨААТҮГ**

41100, Төв аймаг, Булган сум
Утас: 70272849

2023.04.20 № 89 а


Танай _____ -ны № _____ -д

**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Улс болон Орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцсан болно.

Холбогдох санал байхгүй болно.

ЗАХИРАЛ  Ж.БАТТӨГС



4122000136



ТӨВ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

41111 Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272262, Факс: 70272192

2023 04 20 № 07/452
тантай _____-ны № _____-т

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

2022 оны улс болон орон нутгийн төсвийн
хөрөнгө оруулалтын аудитын тайлантай
танилцлаа.

Тайлангийн төсөлд өгөх саналгүй байна.

ы

ДАРГА  Б.НАСАНЖАРГАЛ



711300
My doc: Toot A5



**ТӨВ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

41111 Төв аймаг, Зуунмод сум,

Утас: 70273539, И-мэйл: Tuv.umchi@gmail.com

2023.04.20 № 06/95

танай _____ -ны № _____ -т

**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Тайланд тусгах саналгүй болно.

ДАРГА

Д.БАТЖАРГАЛ

• 412311067

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273465
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn